



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

*“Хүнд хүрсэн санхүүгийн
дэмжлэг”*

<http://www.abts.mn>

ТАНИЛЦУУЛГА

2023.12.01

Манай байгууллага 2001 онд үүсгэн байгуулагдаж өдгөө 22 дахь жилдээ харилцагчидийнхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагыг итгэл төгс ханган ажиллаж байна.

“АБТС” ББСБ нь үүсэн байгуулагдсан цагаасаа үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй зарчмыг баримтлан ажилласаар ирлээ. Бизнесийн орчин, харилцагчийн эрэлт хэрэгцээ хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед бид харилцагч бүрийн онцлог, хэрэгцээнд тулгуурласан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд тасралтгүй нэвтрүүлж, дээд зэрэглэлийн тав тухтай орчинд, мэргэжлийн түвшний санхүүгийн найдвартай үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна.

“АБТС” ББСБ ТАНИЛЦУУЛГА

“АБТС” ББСБ 2001 оны 10 дугаар сарын 4-нд Монголбанкнаас зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ. “АБТС” ББСБ нь банкнаас санхүүгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал, орлого багатай иргэд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд эрэлт хэрэгцээнд нь нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, ажилгүйдлийг бууруулан тогтвортой амьжиргааг нь хангаж, улмаар Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Тодорхой зорилготой, тухайн зорилгодоо хүрэх чин эрмэлзэлтэй, хүчин зүтгэх, хөдөлмөрлөх хүсэлтэй хүн бүрт санхүүгийн туслалцаа үзүүлэн дэмжих нь бидний үйл ажиллагааны үндсэн зорилго юм.

Бид санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, санхүүгийн үйлчилгээг дэвшилтэт мэдээлэл технологитой уялдуулан хөгжүүлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг олон улсын жишигт нийцүүлэн хангахын төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2023 оны 10сарын байдлаар “АБТС” ББСБ нь төслийн болон өөрийн эх үүсвэрээр давхардсан тоогоор нийт 3956 харилцагчдад 70.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.


АБТС ББСБ өнөөдөр олон нийгэд танигдсан, найдвартай санхүүгийн зуучлагч болсон билээ. Манай чадварлаг боловсон хүчин, зохистой удирдлага, хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг, нэгдмэл сонирхолтой, тодорхой зорилгод чиглэсэн хамт олны маань хичээл зүтгэл, хөдөлмөр энэхүү амжилтын үндэс болж байгаа бөгөөд цаашдын амжилтад хүргэнэ гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“АБТС”ББСБ нь үүсгэн байгуулагдсан 2001 оны эцэстэй харьцуулахад 2023 онд нийт актив 224 дахин, нийт зээл 171 дахин нэмэгдсэн бөгөөд өөрийн хөрөнгө 142.5 дахин өсчээ. Өнгөрсөн оны эцсээс нийт актив 3,9%, өөрийн хөрөнгийн хэмжээ 4%-иар тус тус өссөн байна. 2023 оны байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 25%-иар буурсан нь өнгөрсөн онд Ковид цар тахлийн улмаас иргэд, ААН-н санхүүгийн чадварт үзүүлсэн хохиролын нөлөөлөл багасч мөн АБТС ББСБ нь бодлогын хувьд ч зээлийн багцын хэмжээнээс илүү түүний чанарт анхаарах болсонтой холбоотой юм.

АБТС ББСБ нь одоогийн байдлаар 19,263,697,965 төгрөгийн актив, 9,811,680,017 төгрөгийн зээлийн багцтай байна. Чанаргүй зээлийн багц 183,031,607 төгрөг байна.

Зураг 1. Нийт актив, зээл (сая төгрөг) Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа (баруун тэнхлэг)




Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон өөрийн хөрөнгө болон нийт активын харьцаа нь 20%-с доошгүй байх бөгөөд 2022 оны байдлаар манай байгууллагын зохистой харьцаа 26,7%-р хангаж байгаа болно


Зураг 2. Нийт актив, өөрийн хөрөнгө (сая төгрөг)



Зураг 3. Зээлдэгчдийн ангилал



Зураг 4. Зээл олголт салбараар



ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

“АБТС” ББСБ өнөөдрийн байдлаар бизнесийн зээл, авто машины лизингийн зээл, хэрэглээний зээл, орон сууцны зээл, хашаа байшин худалдаж авах, засвар хийх зээл, цалингийн зээл зэрэг нийт 22 төрлийн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн боломжит хугацаагаар иргэд, ААН-д санал болгож байна. Зээлийн бүтээгдэхүүний онцлог болон хугацаанаас нь хамааран зээлийн сарын хүү 0.7%-3.0% хувийн хооронд хэлбэлзэж байна.


Зээлийн бүтээгдэхүүний төрөл

- Барилгын зээл /төгрөг, валют/
- Хүнсний ногооны зээл
- Зоорь агуулахын зээл
- Тээвэр логистикийн зээл
- Худалдааны зээл
- Гар урлалын зээл
- Жижиг үйлдвэрлэлийн зээлийн шугам /төгрөг, валют/
- Орон сууцны зээл
- Орон сууцны нөхцөл сайжруулах зээл
- Хашаа байшин худалдан авах зээл
- Гэр хорооллын нөхцөл сайжруулах зээл
- Автомашины лизингийн зээл
- Хэрэглээний зээл

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

АБТС ББСБ нь 8 хувь нийлүүлэгчтэй. Тэдгээрийн төлөөлөл болох 3хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр удирдуулан Гүйцэтгэх захирал, 5 гишүүн бүхий зээлийн хороо, 5 эдийн засагч, санхүүгийн 2 ажилтан, маркетингийн менежер зэрэг бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хуулийн зөвөлгөөг Монгол өмгөөлөгч хуулийн фермээс аутсорсингийн үйлчилгээ авч ажиллаж байна.

АБТС ББСБ” ХХК-ийн БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

АБТС ББСБ нь ажилгүйдлийг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагууд болон гадаадын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчдаас хэрэгжүүлсэн төрөл бүрийн хөтөлбөр, төсөлд хамрагдан хамтран ажиллаж, иргэд, аж ахуйн нэгжид бичил зээлийг дамжуулан олгоход арвин туршлага хуримтлуулсан билээ.

“Тогтвортой амьжиргаа” төсөл, Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангийн төсөл. Манай байгууллага Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банкны шугамаар хэрэгжүүлсэн “Тогтвортой амьжиргаа” төсөл болон Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангийн төслийн хүрээнд Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд нийт 3.5 тэрбум төгрөгийн 351 зээлийг олгосноос ядуу болон бага орлоготой иргэдэд 1.7 тэрбум төгрөгийн зээл ногдож байна. Үүний үр дүнд 593 хүн шууд болон 693 хүн шууд бусаар ашиг хүртжээ.

“Шульц глобал Монголиа” төсөл, Ажлын байр нэмэгдүүлэх болон жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор 2014 оны 4 дүгээр сард 2,000,000 ам.долларын санхүүжилтийг татан

төвлөрүүлсэн. Уг санхүүжилтын үр нөлөөгөөр 2016 оны сүүлээр манай компанийн санхүүгийн үзүүлэлт болон зээлийн багц сайжирсан. Тухайлбал зээлийн багц 2,2 дахин өсч давхардсан дүнгээр 681 харилцагчдад 21,4 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна. Төслийн үр дүнд 300 гаруй ажлын байр шинээр бий болсон. Уг төсөл амжилттай хэрэгжиж, зээлийн хүүгийн хамт 2016оны 2-р сард бүрэн төлж барагдуулсан болно.

“Бизнес Партнерс компани” 2016 онд Япон улсын Бизнес Партнерс компаниас хувиараа бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавхийг дэмжих зорилгоор зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн. Тус санхүүжилтын хүрээнд давхардсан тоогоор 637 харилцагчид 22,2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна. Төслийн үр нөлөөгөөр шинээр 200 гаруй ажлын байр нэмэгдэж, өрхийн амьжиргааны түвшин сайжирсан үзүүлэлттэй байна.

Ажлын байр нэмэгдүүлэх төсөл. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн Ажлын байр нэмэгдүүлэх төслийг манай байгууллага 2002-2010 онд амжилттай хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд нийт 416.5 сая төгрөгийн зээл олгосноос гэр хорооллын оршин суугчдад 195 сая төгрөг, алслагдсан дүүрэг, орон нутгийн оршин суугчдад 33.3 сая төгрөгийн зээл олгож, нийт 700 гаруй ажлын байр шинээр бий болгосон билээ.

Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн бичил зээл. Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлсэн “Тогтвортой амьжиргаа” хөтөлбөрийн хүрээнд АБТС ББСБ өөрийн Өмнөговь аймгийн Даланзадгад сум дахь салбараараа дамжуулан орон нутгийн бага орлоготой өрх, эмзэг бүлгийнхэн, иргэд болон малчдад нийт 128.6 сая төгрөгийн 210 зээл олгож, тус төслийг 2003-2004 онд амжилттай хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд сум болон сумаас алслагдсан нутгийн оршин суугчдад 33.3 сая төгрөг, ядуу болон бага орлоготой иргэдэд 117 сая төгрөг, малчдад 37.3 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

“Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах” төсөл. Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хамтран “Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах JFPR MON-9015” төслийг 2005 оны 9 дүгээр сараас 4.5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд АБТС ББСБ нь байшин барих, өргөтгөх, засах, гэр худалдан авах болон засан сэлбэх зориулалтаар 1 сая хүртэлх төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаагаар сарын 0.5%-ийн хүүтэйгээр Баянзүрх дүүргийн орлого багатай иргэдэд олгож төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт 155 хүнд 145 сая төгрөгийн зээл олгосноос 13 хүн шинээр гэр худалдан авч, 57 нь байшин шинээр барьж, 85 нь байшингаа засч сайжруулсан .

Гэрийн зуух төсөл. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын иргэдийн түлшний зарцуулалтыг зохицуулах зорилгоор Азийн хөгжлийн банкнаас Японы Ядуурлыг бууруулах сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр төсөл хэрэгжүүлсэн бөгөөд тус төслийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр сайжруулсан ТТ-03 загварын гэрийн зуухыг гэр хорооллын айл өрхүүдэд тархаах үйл ажиллагаанд манай байгууллага санхүүгийн зуучлалын асуудлыг хариуцан оролцсон.

ТҮҮХЭН ТОВЧООН

2001	Зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч, Монгол улсын 25 дахь Банк бус санхүүгийн байгууллагаар бүртгүүлэв.
2002	- НХХЯамны ажлын байр нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлсэн - Гадаад валют арилжих зөвшөөрөл авав
2003	- СБ аймгийн Баяндэлгэр суманд 1-р салбараа нээв - Өмнөговь аймгийн Даланзадгад хотод 2-р салбараа нээв - ЗГ, ДБ “Өрхийн амьжиргааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэв
2004	Чингэлтэй дүүргийн “Хувийн аж ахуй эрхлэгчдийг дэмжигч шилдэг Банк бус санхүүгийн байгууллага”-р шалгарсан
2005	- Японы ЗГ ядуурлыг бууруулах “Санхүүгийн Худаг” төсөл - АХБ “Гэр хорооллын нөхцөл сайжруулах төслийг хэрэгжүүлсэн
2006	- НХХЯамны Ажлын байр нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэв - Санхүү НББ-ийн “SPINEL” програмыг нэвтрүүлэв
2007	- Дэлхийн банк JFPR MON-9015 гэрийн зуух төслийг хэрэгжүүлэв - Нийгмийн хөгжлийг дэмжигч тэргүүний байгууллага” цол хүрвэв - Санхүүгийн түрээс, итгэлцэл үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авав
2008	НХХЯамны Ажлын байр нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлсэн
2009	МУ-н ЗГ, МҮХАҮТанхим “ТОП-10 ББСБ”-ын нэгээр шалгарсан
2010	- МУ-н ЗГ, МҮХАҮТанхим “ТОП-10 ББСБ”-ын нэгээр шалгарав - МҮХАҮТ-ын “Платинум” гишүүн болов - Казахстан улсын Астана хотод (MFC)-ийн хуралд оролцов - Зохиомж дээд сургуулийн 4 оюутанд тэтгэлэг олгов \ - ОУХНайрамдал зусланд 70ширхэг Сакура төгөл тарив
2011	- МУ ЗГ, МҮХАҮТ “ТОП-10 ББСБ”-ын нэгээр шалгарсан - Японоос санхүүжилт авч Гадаадын хөрөнгө оруулалттай болов - Бичил санхүүгийн хөгжлийн сангийн төслийг хэрэгжүүлсэн
2012	- МУ ЗГ, МҮХАҮТ “ТОП-10 ББСБ”-ын нэгээр шалгарав - Гүрж улсын Тбилиси Бичил Санхүүгийн ОУ-н хуралд оролцсон - Монголын ББСБХолбоо Монголын банк бус санхүүгийн салбарын 2012 оны “Онцлох байгууллага”-р өргөмжлөв

2013	- МУ-н ЗГ, МҮХАҮТ “ТОП-10 ББСБ”-ын нэгээр шалгарсан - www.khunnu.mn санал асуулгаар “2013Оны шилдэг ББСБ” болов - Дорноговь аймаг 1500 ширхэг хайлаас мод тарьсан
2014	2 сая ам.долларын гадаад эх үүсвэр татаж зээл олгов - ЧД 25 хүүхдэд “Муурын байшин” мюзикл жүжиг үзүүлэв
2015	500,000 ам.долларын дунд хугацааны гадаадын санхүүжилт авав - Чех Прага БСТ (MFC) -ийн ОУ-н хуралд амжилттай оролцсон
2016	- Монголын ББСБХолбоо “Оны шилдэг хөрөнгө оруулагч” байгууллагаар өргөмжлөн Алтан Од шагнал хүртэв - АБТС ББСБ байгуулагдсаны 15 жилийн ой тохиов - Зорилтот бүлгийн хүүхдэд жил бүр хичээлийн хэрэгсэлтэй цүнх олгож эхлэв
2017	- МББСБХ-ны 2016 оны шилдэг “Хөрөнгө оруулагч” байгууллагаар шалгарч бусад ББСБ төлөөлөгчдөд гадаадын хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл хүргэх уулзалт хийв - ЧД-н хүүхдүүдэд “Эх үрсийн баяр”-н бэлэг олгож эхэлсэн
2018	- Өрх толгойлсон 12 эмэгтэйд зээлийн үйлчилгээ үзүүлсэн. - СЗХ-с төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөл авсан - Бага хүү, урт хугацаа бүхий моргежийн зээлийг олгосон
2019	- СЗХ ХО-ийн зөвлөгөө, мэдээлэл өгөх тусгай зөвшөөрөлав - Шинэ оффисийн байранд орсон - Цус сэлбэлт судлалын үндэсний төвд цусаа бэлэглэх аян хийсэн
2020	Цар тахалын үед харилцагчдийн зээлийн дарамтийг бууруулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хөтөлбөр хэрэгжүүлсэн
2021	Цар тахалын үед харилцагчдийн зээлийн дарамтийг бууруулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хөтөлбөр хэрэгжүүлсэн
2022	“Тэрбум мод” хөтөлбөрт нэгдэж хандив өргөж мод тарив
2023	- Камбож улсад санхүүгийн байгууллагын туршлага судлах хамтийн ажиллагааг сайжруулах сургалтанд суув. - Япон улсаас хөрөнгө оруулалт авч автомашины зээлийн бүтээгдэхүүн гаргав. - Цус сэлбэлт судлалын үндэсний төвд цус хандивлав

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

АБТС ББСБ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа нийгмийн сайн сайхныг санхүүжүүлэхийг өөрийн үндсэн үүрэг хэмээн ажиллаж ирсэн бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс дурдвал; Дорноговь аймагт хайлаасан төгөл нөхөн сэргээх төслийг хэрэгжүүлэхэд оролцож, Их Уст Туул ТББ-тай хамтран 1500 ширхэг мод тарьсан, ОУХНайрамдал зуслан Японоос авчирсан 70ширхэг Сакура аар төгөл байгуулав. Зохиомж дээд сургуулийн 4 оюутны жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон. “Миний төсөөлж буй Монголын ирээдүй” сэдэвт ил захидал, мэндчилгээний зургийн уралдааныг дунд сургуулийн сурагчдын дунд Монголын Уран Зургийн Галерейтай хамтран зохион байгуулсан. Монголын ББСБ-ын холбоо, “Хүүхдийн төлөө амьдрах ухаан төв” ТББ-аас зохион байгуулсан “Оюунлаг залуус Монголын ирээдүй” хандивын аянд оролцож, бүтэн болон хагас өнчийн хүүхдүүдийн сурч боловсрох, өөрсдийгөө хөгжүүлэх орчинг бүрдүүлэх зорилгоор компьютерийн өрөөг тохижуулахад тус дэмжлэг үзүүлсэн. 1000цүнх аяны хүрээнд иж бүрэн хичээлийн хэрэгсэл, Чингэлтэй дүүргийн зорилтот бүлгийн хүүхдүүдэд эх үрсийн баярын бэлэг олгох ажлийг уламжлалт арга хэмжээ болгон жил бүр олгосоор байна.



БИДНИЙ АМЖИЛТ

Монгол улсын Засгийн газар, МҮХАҮТ “ТОП-10 ББСБ” 2009-2013. Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо “салбарын 2012 оны Онцлох байгууллага”. 2013 он олон нийтийн санал асуулгаар “Оны шилдэг банк бус санхүүгийн байгууллага”. 2016 он Монголын Банк бус Санхүүгийн Байгууллагын Холбооноос “Оны шилдэг хөрөнгө оруулагч” байгууллагаар өргөмжлөгдөн Алтан Од шагнал хүртэв.



ЦААШДЫН ЗОРИЛТ:

Бидний цаашдын зорилт нь Хөдөө аж ахуй, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн салбарт ажиллаж буй эмэгтэй бизнес эхрлэгчдийг дэмжих мөн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх ногоон зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж үүний дотор ногоон төгөл ой, эко автомашины зээлийн хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж үйл ажиллагаагаа өргөжин тэлж ажиллах ирээдүйн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

“АБТС ББСБ” ХХК

Улаанбаатар – 14240

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Жамьян гүний гудамж 18/2, Мөрү тауэр, 1301 тоот

Утас: 318-133

Цахим шуудан: info@abts.mn

Цахим хаяг: www.abts.mn